



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/85

Сүхбаатар сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "б", 30 дугаар зүйлийн 30.1.16. Захиргааны ерэнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар /COVID-19/-ын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх түр журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийсэн актыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/, Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 16 -ны
өдрийн А/88 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

“Коронавируст халдвар /COVID-19/-ын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх түр журам”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь шинэ коронавируст халдварын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд энэхүү түр журам болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, журам, зааврыг мөрдөнө.

Хоёр. Халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаа

2.1. Халдвар бүртгэгдсэн газрын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр гарах, орох чиглэлийн тээврийн хэрэгсэл бүрд халдваргүйжүүлэлт хийнэ.

2.2. Халдвар бүртгэгдээгүй газрын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр орох чиглэлд нэвтрэх тээврийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийнэ.

2.3. Тээврийн хэрэгсэлд хийх халдваргүйжүүлэлтийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.8 дахь заалтад заасан заасны дагуу халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

2.4. Монгол Улсын бүртгэлд бүртгэгдсэн хэрэглэх ашиглах заавар нь баталгаажсан, хэрэглэх хугацаа хүчинтэй, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, хаяг шошго тодорхой бодисыг халдваргүйжүүлэлтэд ашиглана.

Гурав. Халдваргүйжүүлэлт хийх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

3.1. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийхдээ Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдварын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар”, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын баталсан “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа” зэрэгт тусгасан халдваргүйтгэлийн бодисыг ашиглан, аргачлалын дагуу хийнэ.

3.2. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх ажилтныг хувийн хамгаалах хувцас, хамгаалах хэрэгсэл, халдваргүйтгэлд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна.

3.3. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийсэн тухай актыг 2 хувь үйлдэж, жолоочид нэг хувийг өгнө.

3.4. Халдваргүйжүүлэлт хийж буй аж ахуйн нэгж, байгууллага нь халдваргүйтгэлийн бодисын чанар, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

Дөрөв. Тээврийн хэрэгслийн жолоочийн үүрэг

4.1.Тээврийн хэрэгслийг аймаг, суманд нэвтрэх шалган нэвтрүүлэх цэгийн заасан газарт зогсоож, халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.

4.2.Шалган нэвтрүүлэх цэгт ажиллаж байгаа холбогдох байгууллагын ажилтнуудын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, халдваргүйжүүлэлтийн ажилтны зөвлөмж, зааврыг мөрдөнө.

4.3.Халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай актын нэг хувийг авч, шаардлагатай тохиолдолд дараагийн шалган нэвтрүүлэх цэгт шалгуулна.

4.4.Тээврийн хэрэгслийн гадна, дотор талыг тогтмол цэвэрлэн, хог хаягдлыг уут саванд хийж, суурин газрын хогийн цэгт хаяна.


4.5.Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийсэн тухай актыг хуурамчаар үйлдэх, дахин ашиглахыг хориглоно.

Тав.Бусад

5.1.Халдваргүйжүүлэлт хийлгээгүй тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрүүлэхийг хориглоно.

5.2.Энэхүү түр журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 16 -ны
өдрийн 185 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ
ХИЙСЭН АКТ

20 оны сарын өдөр цаг

Шалган нэвтрүүлэх товчооны нэр

1. Тээврийн хэрэгслийн улсын дугаар
2. Халдваргүйжүүлэлт хийсэн байгууллагын нэр
3. Халдваргүйжүүлэлт хийсэн арга:

Шүрших Мананцаржуулах Уураар утах Туулах

4. Халдваргүйжүүлэлт хийсэн бодисын нэр, уусмалын концентраци

Ариутгагчийн нэр /
..... /
гарын үсэг